

ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ СУРАГЧДЫН МЭРГЭЖИЛ СОНГОЛТОД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

*Д. Ариунтогос
Магистр*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль*

ariuntogod@gmail.com

***Хураангуй:** Энэхүү судалгаа нь сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн улсын болон хувийн сургуулиудын сурагчдын жишээн дээр судлав. Чанарын судалгааны бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар өгөгдөл цуглуулан судаллаа.
Түлхүүр үг: Жендэрийн хэвшмэл ойлголт, мэргэжил сонголт, сургуулийн орчин, ажил олгогч*

УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлав. Үүний тулд Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг, Баян-Уул сумдыг судалгааны талбараар сонгов. Судалгаа нь цаашид хүйсээс хамаарсан цалингийн зөрүүг багасгахын тулд түүнд нөлөөлөгч суурь хүчин зүйлсийг судалж, илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Дунд сургуулийн хүүхдүүдийн мэргэжил сонголтод жендэрийн хэвшмэл ойлголт хэрхэн нөлөөлж байгааг илрүүлснээр сургуулийн хүүхдүүдийн мэргэжил сонголт дахь жендэрийн хэвшмэл ойлголтын нөлөөг бууруулахад

чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах суурь болох боломжтой.

Ази Номхон далайн бүс нутгийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн төлөв байдал 2022 оны тайланд ажил эрхлэлтийн бүтэц өөрчлөгдөж байгаа нь зохистой хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдийг илүүд үздэг болохыг дурджээ. 1991-2021 оны хугацаанд бүх салбараас ердөө тавт нь л эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өсөлт эрэгтэйчүүдээс өндөр байсан байна. Эрэгтэйчүүдийг өндөр цалин авах боломжтой салбаруудад (IT гэх мэт) тусгаарлаж, эмэгтэйчүүд бага цалинтай салбарт (жишээ нь байр, хоол, үйлчилгээний салбар) ажиллаж байгаатай холбоотойгоор олон улс орны хүйсийн цалингийн зөрүүг арилгах ахиц дэвшил

зогсонги байдалд оржээ. Цалингийн тэгш байдлыг хангахад ахиц дэвшил гаргахын тулд хэд хэдэн чиглэлээр ажиллах шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна: (i) бүх салбарын аж ахуйн нэгжийн түвшинд цалин хөлсний тэгш байдлыг дэмжих; (ii) эмэгтэйчүүдийг өндөр цалинтай салбар, мэргэжлээр ажиллахыг дэмжих; (iii) эмэгтэйчүүдийг илүү өндөр цалинтай салбарт (IT гэх мэт) сургах; (iv) эрэгтэйчүүд давамгайлсан салбарт эмэгтэйчүүдийг ажилд авахгүй байгаа ялгаварллыг бууруулах нь чухал байна.

Мэргэжил сонголтын онолын үндэслэл

Мэргэжил сонголт хэрхэн бий болдог талаар зарим судалгаанд дараах байдлаар илэрхийлжээ. Барууны зарим судалгаанд мэргэжил сонголт нь аливаа талбарт ажиллах хүч болох суурь, хэд хэдэн дараалласан шийдвэрүүдийн цогц [Blau], хөгжлийн үйл явц хэмээн тодорхойлсон. Нөгөөтэйгүүр, мэргэжил сонголт нь ямар нэг үйл явцын жижиг хэсэг биш, харин хүний төрсөн цагаас нь эхэлж өрнөсөөр байдаг амьдралын нөлөөнөөс бий болдог үйл ажиллагаа юм хэмээжээ. Өөрөөр хэлбэл мэргэжил сонголт нь нийгэмшлийн нэгэн хэлбэр болдог байна.

Хүмүүс ажил мэргэжил, карьераа сонгохдоо өөрсдийн хүсэл сонирхол, хэрэгцээгээ хангах

зорилготой байхын зэрэгцээ ажлын талбарт тулгарч болох бэрхшээлүүдийг ч харгалзан үздэг [Гинзберг, 1972]. Мөн энэхүү үйл явц нь олон жилийн туршид бий болсон хүсэл сонирхол, чадвар, бодит байдлаа таньж мэдэж байж гаргах шийдвэр боловч сурагчид ахлах сургуулиа төгссөнөөр танин мэдэх үйл явц дуусгавар болдог байна [Гинзберг, 1972]. Өсвөр насныхан мэргэжлээ сонгоход сонголт хийх боломж, эрсдэл хүлээх чадвар, алдаа мадаг, сорилтыг давах байдал, бие болон сэтгэл зүйн чадавхаа ухамсарласан байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг [Shannon, 1972]. Энэ үед өсвөр насныхан хүүхэд наснаас насанд хүрэгсдийн үе рүү хүрэх шилжилтийн үеийг туулж, төөрөлдөх, өөртөө итгэх итгэлээ алдах байдлыг мэдэрдэг [Shannon, 1972].

Харин судлаачдын үзэж буйгаар мэргэжил сонголтод хамгийн их нөлөөлөгч хоёр орчин байдгийн *нэгдүгээрт*, гэр бүлийн орчин, *хоёрдугаарт*, сургуулийн орчин багтдаг. Drabick (1967) ба Wattenberg (1955) судлаачдын үзэж буйгаар өсвөр насныхны гэр бүл, ялангуяа тэдний эцэг эхийн илэрхийлдэг хүсэл, хүлээлт нь хүүхдийн мэргэжил сонголтоо хийх шийдвэрт хүчтэй нөлөөлдөг. Ингэж нөлөөлж буй эцэг эхчүүдийн дунд дараах хоёр төрлийн эцэг эх хожим нь хамгийн ихээр гэмшдэг байна.

1. Өөрийн ажил мэргэжлийн талбартаа хүссэн шигээ өндөрлөгт хүрч чадаагүй тул хүүхдээ хүргэх гэж тулгасан;
2. Өөрийн ажил мэргэжлийн талбартаа өндөр амжилттай ажиллаж, өөрийн хүүхдээ ч адил замналар явахыг ятгаж, бусад талбарт амжилттай ажиллаж

чадахгүй хэмээн тулгасан [Young, 1927]. Хэдийгээр эцэг эх нөлөөлж болох ч эцсийн сонголт хүүхдэд өөрт нь үлддэг [Young, 1927]. Хоёрдогч хүчин зүйлс буюу сургуулийн орчин, өөрөөр хэлбэл боловсролын тогтолцоо нь мэргэжил сонголтын чухал суурь юм.

Зураг 1. Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлс



Энэхүү ойлголт нь дараах дөрвөн агуулгаар илэрхийлэгдэнэ.

1. Өөрөө болон өрөөл бусад чухал хүмүүсийн харилцаа, хамаарал;
2. Ажил мэргэжил, хүсэл эрмэлзлийн тухай мэдлэг;
3. Өөрийгөө танин мэдэж карьераа уялдуулан ойлгох;
4. Боловсролын үр нөлөө.

Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлс

Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлохдоо судлагдсан байдлын тоймд үндслэн үндсэн нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойллоо. Уг судалгаа сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилго

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар агуулсан ч гэр бүлийн орчин мөн ялгаагүй чухал болохыг бусад судалгаанууд онцолж байна.

Хүүхдийн мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах хувьсагчуудын хүрээнд тоймлож, судалгааны асуултын суурь болголоо (Зураг 1).

Жендэрийн хэвшмэл ойлголт

Жендэрийн хэвшмэл ойлголт нь хүмүүсийг хүйсээс хамаарч ямар байх ёстойг тодорхойлсон ойлголт бөгөөд ихэвчлэн эрэгтэй эмэгтэй байхаас хамаарч гүйцэтгэх болон хүлээх үүрэг, дүр оноох итгэл үнэмшил юм [UN, 2023; Мoуa, 2021]. Тухайлбал өрсөлдөөнт чадвар, давамгайллыг эрэгтэй хүний шинж хэмээн үзэж, уян зөөлөн, мэдрэмтгий шинжийг

эмэгтэйчүүдийн шинж гэж үзэх ойлголт түгээмэл байдаг. Энэ мэтчилэн хүний шинж чанарыг тодорхойлсон хэвшмэл ойлголт нь даамжирсаар эрэгтэйчүүдийг сонголт хийх сэтгэлгээний эрх чөлөөнд хөтөлдөг бол эмэгтэйчүүдийг нийгмийн үзэл бодлыг дагахад хөтлөн аваачдаг [Abele and Wojciszke, 2019].

Хэвшмэл ойлголтын сөрөг тал нь зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шинж байдлыг тодорхойлоод зогсохгүй, тэдний нийгэмд гүйцэтгэх чадамж, үүргийг хязгаарлаж, ажил мэргэжлийн сонголт, амьдралын өдөр тутмын сонголтыг хязгаарлаж байдаг [UN, 2023; Eagly and Karau, 2002; Morales and Garyfano, 2021]. Жендэр хэмээх нийгмийн ойлголт нь бага насанд бий болдог [Golombok and Fivush, 1994] бөгөөд үүнтэй зэрэгцэн хэвшмэл итгэл үнэмшил нь нийгмийн хэвийн үзэгдэл мэт бага нас, өсвөр насны үед бүрэлдэн тогтдог [King et al., 2021]. Өөрөөр хэлбэл 2-5 насанд нийгмийн нөлөөгөөр жендэрийн хэвшмэл ойлголтын суурь тавигддаг байна [King et al., 2021].

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлахдаа чанарын судалгааны хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргыг ашигласан бөгөөд тодорхой

мэргэжлийг сонгох шийдвэрт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг илрүүлэх, шалтгааныг тодорхойлж, шинжлэв. Чанарын судалгааны хагас бүтэцлэгдсэн ярилцлага нь судалгааны сэдвийн хүрээнд урьдаар төлөвлсөн асуултуудыг асууж, судалгаанд оролцогчийн байр суурь, үзэл бодол, амьдралын туршлагыг сонсож, харилцан ярилцах арга юм. Ялангуяа яагаад, хэрхэн, яаж хэмээх шалтгаан заасан асуултуудыг лавшруулан асууснаар тоон судалгаагаар илрүүлэх боломж багатай зүйлсийг судалдаг онцлогтой. Хагас бүтэцлэгдсэн учир судалгааны явцад шинээр илэрч буй асуудлуудын талаар нэмж, дэлгэрүүлж ярилцаж болдог уян хатан судалгааны арга юм. Үүний тулд сэдэвтэй холбоотой судлагдсан байдлыг тоймлон, жендэрийн хэвшмэл ойлголтыг тодорхойлж, хот, суурин орон нутгийн нийгмийн амьдралын ялгаатай байдал сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөхцөлдүүлж байж болох шалтгааныг илрүүлэх асуултуудыг тоймлов.

Чанарын судалгааны ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагад сумын төв, аймгийн төв, Улаанбаатар хотын сурагчдыг хамруулав. Мөн сэдэвтэй холбогдуулж багш, эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн нийгмийн ажилтан, судлаач, иргэний нийгмийн байгууллага, бодлого боловсруулагчдын төлөөлийг

оролцуулав. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо түүврийн хэд хэдэн аргыг хослуулав. Нэгдүгээрт цас бөмбийлөх аргаар түүвэрлэсэн бөгөөд ингэхдээ судалгааны зорилгоо танилцуулж, эхний оролцогчоос дараагийн боломжит оролцогчийг асууж, холбогдох байдлаар бүрдүүлэв. Судалгаанд оролцогчдын санал болгож буй хүнийг сонгохдоо тэдний гэр бүл, найз нөхөд, шууд хамааралгүй хүнийг сонгохыг эрмэлзэв. Мөн дунд сургуулиудын багш, нийгмийн ажилтанд судалгааны зорилгоо танилцуулж, судалгаанд оролцох сурагчдыг сонгов.

Судалгаанд газарзүйн хувьд ялгаатай хоёр байршлыг (Улаанбаатар хот, Говь-Алтай аймаг) сонгохдоо цаг хугацааны хувьд судалгаа явуулах боломжийг түлхүү харгалзав (Зураг 2, Зураг 3).

Зураг 2. Говь-Алтай аймагт судалгаанд хамрагдсан сургуулиудын байр



Эх сурвалж: Судлаачдын боловсруулснаар

Зураг 3. Улаанбаатар хотод судалгаанд хамрагдсан сургуулиудын байршил



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Говь-Алтай аймаг нь судалгааны 2 дахь талбар бөгөөд Улаанбаатар хотоос 1001 км зайтай, хол байршилтай аймгуудыг төлөөлж сонгогдсон. Аймгийн төв, сумын төв, орон нутгийн малчдын хүүхдүүд нүүдлийн соёл, өдөр тутмын амьдрал дахь улирлын онцлогоос шалтгаалан өөр өөр амьдралын нөхцөлтэй тулгардаг. Иймд хязгаар нутгийг сонгох нь

тэнд хүүхдүүд хэрхэн сургуульд хамрагддаг, цаашид суралцах мэргэжлээ сонгохдоо хэрхэн сонгодог арга замыг судалж судалгааны үр дүнг баяжуулах боломжтой. Алслагдсан газарт уламжлалт соёл, түүний үнэт зүйлс хүүхдүүдийн мэргэжлийн сонголтод нөлөөлдөг байх магадлалтай юм.

Судалгааны түүвэрт ганцаарчилсан 19, бүлгийн 18, нийт 37 удаагийн ярилцлагад 58 ахлах ангийн (IX-XII анги) сурагчид, 11 эцэг эх, нийгмийн ажилтан, багш, бодлого боловсруулагч, иргэний нийгмийн төлөөлөл нийт 68 оролцогчдыг хамруулав.

Хүснэгт 1. Түүвэр сонголт ярилцлагын хэлбэрээр

Ярилцлага	Ганцаар-чилсан	Бүлгийн	Нийт
Эрэгтэй	10	2	12
Эмэгтэй	9	2	11
Эмэгтэй, эрэгтэй оролцогчидтой	-	13	13
Нонбайнари күйр, трансгендэр эмэгтэй, күйр эрэгтэй	-	1	1
Нийт	19	18	37

Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төвийн хүн амын тоо харилцан адилгүй тул түүврийн нийт тоог хүн амын тоотой уялдуулж тогтоолоо. Гэхдээ энэ нь бүрэн төлөөлөх тоон утга биш тул ялгаатай байдлыг илүү чухалчлав.

Мөн сургуулийн өмчийн хэлбэрээс хамаарч сургуулиуд хичээлийн агуулга, заах арга ялгаатай болон хичээлээс гадуур сурагчдыг хөгжүүлэх өөр өөр орчныг бий болгосон байдаг тул өмчийн 3 хэлбэрийн сургуулийг сонгов. Тиймээс судалгаанд хамрагдах сурагчдын суралцаж буй сургуулийг сонгохдоо Улаанбаатар хот, ГАА-ийн улсын, хувийн болон олон улсын сургуулиудыг хамруулав (Хүснэгт 2).

Ярилцлагуудыг хөрвүүлж МАХQDA програмын тусламжтайгаар кодолж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд фрэймвөрк шинжилгээний аргыг ашиглан ярилцагчийн хэлсэн үгийн утга санаа, агуулга, холбоос мөн нуугдмал утгад шинжилгээ хийв.

Ингэхдээ хөрвүүлсэн ярилцлагыг ойлгож, гол сэдвүүдийг тодруулан, кодолж хоорондын уялдааг зураглаж, тайлбарлан шинжлэв [Ritchie and Spencer, 1994].

Хүснэгт 2. Түүвэр сонголт байршил, хүйсийн, сургуулийн өмчийн хэлбэрээр

Байршил	Улаанбаатар хотын сургууль			ГАА-ийн төв Есөнбулаг		Нийт
	Улсын	Хувийн	Олон улсын	Улсын	ГАА-ийн Баян-Уул сум	
Сургуулийн өмчийн хэлбэр	Улсын	Хувийн	Олон улсын	Улсын		
Эр	10	4	1	5	3	23
Эм	11	2	2	14	3	32
Жендэр күйр	2	1	-	-	-	3
Нийт						58

Хүснэгт 3. Сурагчдаас бусад түүвэр сонголт байршил, төлөөллийн хэлбэрээр

Байршил	Улаанбаатар хот	ГАА-ийн төв Есөнбулаг	ГАА, Баян-Уул сум	Нийт
Сургуулийн нийгмийн ажилтан	1	1	1	3
Багш	1	2	1	4
Эх	0	1	1	2
Эцэг	0	1	1	2
Бодлого боловсруулагч	0	1	0	1
ТББ-ийн төлөөлөл	1	0	0	1
Нийт				11

МАХQDA програмд нийт 45 код үүсгэв. Ингэхдээ сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг ажлын нөхцөл, цалин, дадлагажсан байдал, хүсэл сонирхол, амьдралын асуудал, багш, сурагч, гэр бүлийн гишүүд, нийгмийн жендэрийн хэвшмэл ойлголт гэх мэтээр кодолж, хамгийн түгээмэл давтамжаар чухалчлан сэдэвчилж шинжлэв.

Хүснэгт 4. Хөрвүүлсэнд ярилцлагад оноосон кодны жишээ

Хувьсагч	Хувьсагч	Код	Хувьсагчийн
Мэргэжил	Ажлын нөхцөл	1	Мэргэжил-нөхцөл
	Цалин	2	Мэрг.цалин
	Дадлага/Internationalship/	3	Мэрг.дадлага
	Хүсэл сонирхол	4	Мэрг.Хүсэл-сонирхол
	Амьдралын асуудал	5	Мэрг.Амьдрал-асуудал
	Охидын мэргэжил	6	Мэрг.эм
	Күйр сурагчдын мэргэжил	6.7	Күйр.мэрг
	Хөвгүүдийн мэргэжил	7	Мэрг.эр
	Мэргэжил сурталчлах өдөрлөг	8	Мэрг.МС өдөрлөг
Сурагчид	ЖХО (Жендэрийн хэвшмэл ойлголт)	9	Сур.ЖХО
	ЖХО (Жендэрийн хэвшмэл ойлголт)-гүй	9.1	Сур.ЖХО
	Хувь хүний онцлог чанар	10	Сурагч-Хувийн онцлог
	Хувь хүний онцлог чанар харгалзаагүй	10.1	Сурагч-Хув.онцлог
Багш	ЖХО (Жендэрийн хэвшмэл ойлголт)	11	Багш ЖХО
	Мэдлэг	12	Багш Мэдлэг
	Заах арга	13	Багш-Заах арга
	Хандлага	14	Багш-хандлага

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ


Дунд сургуулийн сурагчдын мэргэжил сонголтод гэр бүл, нийгмийн орчин суурь нөхцөлдүүлэгч хүчин зүйл болж

байна. Үүний зэрэгцээ шат, шатны боловсролын байгууллагын багш нарын мэдлэг, чадвар, хандлага, сургалтын хөтөлбөр болон сургуулийн өмчийн хэлбэр, зохион байгуулалт мэргэжил сонголтод голлох нөлөөтэй байна (Зураг 4). Сургуулийн орчин нь гэр бүл, нийгмийн тусгал тул сурагчид сургуулийн орчинд гэр бүл, нийгмийн нөлөөг түгээж, жендэрийн зарим хэвшмэл ойлголтыг батжуулж, хэвшүүлж байна. Энэ дотроос багш, эх, эцэг, асран хамгаалагчид, ажил олгогчдын жендэрийн хэвшмэл ойлголт зарим талаар мэргэжил сонголтод нөлөөлж байгаа нь ажиглагдлаа.

Судалгааны үр дүнг дараах хэсэгт дэлгэрүүлж шинжлэн дүгнэлээ.

Судалгаанд оролцсон охид, хөвгүүдийн мэргэжил сонголтын эхэнд мэдээллийн технологийн инженер (21,9%-26,1%) байв. Удаах сонголт охидын хувьд анагаах ухаан, сэтгэлзүйчийн мэргэжил тус бүр 15,6 хувь байна. Хөвгүүдийн хувьд удаах сонголт нь анагаах ухаан (17,4%) байна. Күйр сурагчид хуульч, социологич, олон улсын харилцаа гэх нийгмийн ухааны мэргэжлийг сонгожээ (Хүснэгт 5). Мэргэжил сонголтын хувьд жендэрийн хэвшмэл ойлголт төдийлөн хамааралгүй мэт ажиглагдаж байна.

Зураг 4. Сурагчдын мэргэжил сонголт нөлөөлөгч хүчин зүйлсийн зураглал



Газарзүйн байршлаар ангилж үзвэл (Хүснэгт 6) хотын сурагчдын хувьд олон янзын мэргэжил (12 бүлэгт хамаарах) сонгосон бол аймгийн

төвийн сурагчид хотын сурагчдаас цөөн (6 бүлэгт хамаарах), сумын төвийн сурагчдаас (4 бүлэгт хамаарах) олон төрлийн мэргэжил сонгосон байна. Сумын төвийн сурагчид цөөн тооны мэргэжил,

хотын сурагчид олон төрлийн мэргэжил сонгож байгаа нь түүврийн тооны зөрүү болон мэдээллийн ялгаатай хүртээмж хэмээх хоёр үндсэн шалтгаантай байж болохоор байна.

Их дээд сургуульд элсэхээр төлөвлөж буй сурагчдын мэргэжлийн чиглэлийг хүйсээр харьцуулан үзэхэд дараах үр дүн харагдаж байна. Улсын сургуулийн судалгаанд хамрагдсан сурагчдыг 100 хувь (Хүснэгт 6) гэж үзвэл түүнээс хамгийн өндөр буюу 22,9% нь мэдээлэл технологийн салбарыг сонгон элсэнэ гэжээ.

Мэдээлэл технологийн салбарт сонгогчдын 25% нь эмэгтэй, 22,9% нь эрэгтэй байна. Үүний дараагаар нийт сурагчдын 14,6% нь Сэтгэл зүйч, анагаах ухааны мэргэжлүүдийг тус бүр сонгон суралцах төлөвтэй байгаа бол Сэтгэл зүйч мэргэжлийг сонгосон сурагчдын 17,9% нь эмэгтэй, 11,1 хувь нь эрэгтэй байна. Анагаах ухааны эмч, биохимич, нийгмийн эрүүл мэнд зэрэг мэргэжлийг сонгогчдын 17,9 хувь нь эмэгтэй, 11,1 хувь нь эрэгтэй байна.

Хүснэгт 5. Судалгаанд оролцсон сурагчдын мэргэжил сонголт (хүйсээр)

Мэргэжил	Хүйс		Бусад	Нийт хувь
	Эм	Эр		
Сэтгэлзүйч, сэтгэл судлаач	15,6%	8,7%		12,1%
Мэдээллийн технологийн инженер	21,9%	26,1%		22,4%
Архитектор	9,4%			5,2%
Анагаах ухаан (эмч, биохимич, нийгмийн эрүүл мэнд)	15,6%	17,4%		15,5%
Өмгөөлөгч, хуульч		8,7%	33,3%	5,2%
Инженер (авто, замгүүр, физик, дууны)	9,4%	8,7%		8,6%
Цэрэг, цагдаа	6,3%	8,7%		6,9%
Онгоцны нисгэгч	3,1%			1,7%
Бизнес	6,3%			3,4%
Улс төрч	3,1%			1,7%
Тогооч		4,3%		1,7%
Социологич			33,3%	1,7%
Олон улсын харилцаа			33,3%	1,7%
Сонгоогүй	3,1%	13,0%		6,9%
Хариулаагүй	6,3%	4,3%		5,2%
Нийт	100,0%	100,0%	100,0%	100,0%

Дээрх тоон мэдээллээс үзвэл улсын сургуулийн сурагчид нь мэдээлэл технологи, сэтгэл судлал, анагаах ухааны мэргэжлүүдийг сонгон суралцах нь түгээмэл байгаа бол тухайн элсэгчдийн дунд охид давамгай байгаа нь цөөн тооны мэргэжлүүдээс охидууд бөөнөөр сонголтоо хийдэг байж болох дүр зураг харагдаж байна. Тухайн гурван мэргэжлийг сонгогчдын тоо

олон байгаа нь дараах шалтгаан нөхцөлөөс мөн хамаарч байж болно. Анагаах ухаан, Сэтгэл судлалын мэргэжлүүдийн хувьд түгээмэл байдаг буюу олон нийтэд танигдсан байдал нь нэгдүгээрт томоохон нөлөө үзүүлж байна. Мөн тухайн мэргэжлийг сонгон суралцагчид нь эмэгтэй хүйсийнхэн давамгайлж байгаа нь эмэгтэй хүүхэд нийгмийн суурьтай харилцан ярилцдаг мэргэжил эзэмших хэрэгтэй, эмэгтэй хүүхэд зөөлөн гартай учраас эмч болох хэрэгтэй гэх мэт нийгэмд түгээмэл байдаг ЖХО-оос үүдсэн нөлөөллөөс хамаарч болно. Энэ нь эргээд тухайн мэргэжлийн эрэлтийг өндөр байхад нөлөө үзүүлж байх боломжтой. Мэдээллийн технологийн мэргэжлийн хувьд цалин хангамж, ажлын байрны орчин нөхцөлөөс хамаарсан эрэлт гэж харж болохоор байна. Учир нь тухайн салбарын боловсон хүчин нь бусад салбараас бага цагаар өөрийн хүссэн орчноос ажиллаж, өндөр орлого олох боломжтой гэдэг ойлголт нийгэмд түгээмэл байдаг нь тус судалгааны явцад ажиглагдаж байсан.

Хүснэгт 6. Судалгаанд оролцсон сурагчдын мэргэжил сонголт (байршлаар)

Мэргэжил	Сурагчдын байршил			Нийт
	Хот	Аймгийн төв	Сумын төв	
Сэтгэлзүйч, сэтгэл судлаач		26,3%	33,3%	12,1%
Мэдээллийн технологийн инженер	18,2%	26,3%	33,3%	22,4%
Архитектор	3,0%	5,3%	16,7%	5,2%
Анагаах ухаан (эмч, биохимич, нийгмийн эрүүл мэнд)	15,2%	15,8%	16,7%	15,5%
Өмгөөлөгч, хуульч	6,1%	5,3%		5,2%
Инженер (авто, зам-гүүр, физик, дууны)	12,1%	5,3%		8,6%
Цэрэг, цагдаа	12,1%			6,9%
Онгоцны нисгэгч	3,0%			1,7%
Бизнес	6,1%			3,4%
Улс төрч	3,0%			1,7%
Тогооч	3,0%			1,7%
Социологич	3,0%			1,7%
Олон улсын харилцаа	3,0%			1,7%
Сонгоогүй	12,1%			6,9%
Хариулаагүй		15,8%		5,2%
Нийт	100,0%	100,0%	100,0%	100,0%

Хувийн сургуульд суралцагчдын хувьд (Хүснэгт 8) мэдээллийн технологи, анагаах ухаан, инженерийн чиглэлийн мэргэжлүүдийг ихэнх хувь нь сонгожээ. Судалгаанд оролцогч хувийн сургуулийн сурагчдыг 100% гэж үзвэл 28,6% нь мэдээллийн технологи, 14,3% нь анагаах ухаан, 14,3% нь инженерийн мэргэжил сонгосон

байна. Тэдгээрээс хүйсийн хувьд мэдээллийн салбарын мэргэжил сонгогчдын 50% нь эрэгтэй, анагаахын салбарын 25% нь эрэгтэй бол инженерийн салбарын 50% нь эмэгтэй байна

Хүснэгт 7. Улсын сургуулийн сурагчдын мэргэжил сонголт (хүйсээр)

Улсын сургууль	Хүйс		
	Эм	Эр	Бусад
Сэтгэл зүйч	17,9%	11,1%	
Мэдээллийн технологийн инженер	25,0%	22,2%	
Архитектор	7,1%		
Анагаах ухаан (эмч, био-химич, нийгмийн эрүүл мэнд)	17,9%	11,1%	
Өмгөөлөгч, хуульч		11,1%	50,0%
Инженер (авто, зам-гүүр, физик, дууны)	7,1%	11,1%	
Цэрэг, цагдаа	7,1%	5,6%	
Онгоцны нисгэгч	3,6%		
Бизнес	3,6%		
Тогооч		5,6%	
Социологич			50,0%
Сонгоогүй	3,6%	16,7%	
Хариулаагүй	7,1%	5,6%	
Нийт	100,0%	100,0%	100,0%

Тоон мэдээллийг дүгнэн үзвэл хувийн сургуулийн сурагчид ч мөн ялгаагүй нийгэмд түгээмэл байх мэргэжлүүдээс сонгон суралцах хандлага давамгайлж байгаа болох нь харагдаж байна. Улсын сургуулийн сурагчдаас ялгаатай нь инженерийн мэргэжлээр суралцах хүсэл сонирхолтой сурагчдын тоо өндөр ба түүн дотроо эмэгтэй сурагч давамгайлж байна. Энэ нь хувийн сургуулиудын дотоод орчин, сургалтын хөтөлбөр эсвэл хувь

сурагчийн хүсэл тэмүүлээс шалтгаалсан нөлөөлөл байж болно.

Хүснэгт 8. Хувийн сургуулийн сурагчдын мэргэжил сонголт (хүйсээр)

Хувийн сургууль	Хүйс		Бусад
	Эм	Эр	
Мэдээллийн технологийн инженер		50,0%	
Анагаах ухаан (эмч, био-химич, нийгмийн эрүүл мэнд)		25,0%	
Инженер (авто, зам-гүүр, физик, дууны)	50,0%		
Цэрэг, цагдаа		25,0%	
Улс төрч	50,0%		
Олон улсын харилцаа			100,0%
Нийт	100,0%	100,0%	100,0%

Олон улсын хөтөлбөртэй сургуулийн судалгаанд оролцогч сурагчдын хувьд (Хүснэгт 9) архитектур, анагаах ухаан, бизнесийн төрлийн мэргэжлүүдийг сонгон суралцах нь түгээмэл байна. Нийт судалгаанд оролцогчдын 33,3 хувь Архитектор, 33,3 хувь анагаах ухаан, 33,3 хувь бизнесийн чиглэлийн мэргэжил сонгосон гэжээ.

Хүснэгт 9. Олон улсын сургуулийн сурагчдын мэргэжил сонголт (хүйсээр)

Олон улсын сургууль	Хүйс		
	Эм	Эр	Бусад
Архитектор	50,0%		
Анагаах ухаан (эмч, био-химич, нийгмийн эрүүл мэнд)		100,0%	
Бизнес	50,0%		
Нийт	100,0%	100,0%	

Үүнээс үзвэл олон улсын хөтөлбөртэй сургуулийн сурагчдын


улсын болон хувийн сургуулийн сурагчдаас мэргэжил сонголтын чиглэлийн хувьд ялгаатай байдал ажиглагдаж байна. Энэ нь тухайн сурагчдын ирээдүйн зорилго, нийгмийн хүрээлэл, гэр бүлийн орчин зэргээс хамаарч байж болох юм.

Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжлэхдээ судлаачдын субъектив нөлөөг бууруулах үүднээс МАХQDA програм дээрх кодуудын хоорондын таталцлыг үүсгэхэд мэргэжил сонголтод ямар үзүүлэлт хэрхэн хамаарч байгааг Зураг 5-д харуулж байна. Код бүрийн ард хэчнээн удаад давтагдсан давтамж хаалтанд тэмдэглэгдсэн байна. Сурагчдын мэргэжил сонголтод хамгийн их хамаарч байгаа хүчин зүйлст:

- Багшийн хандлага (67),
- Тухайн мэргэжлийн ажиллах орчин нөхцөл (61),
- Сурагчийн тухайн мэргэжилд тэмүүлэх сонирхол (53),
- Нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголт (42),
- Сурагчдын жендэрийн хэвшмэл ойлголтыг үл зөвшөөрөх байдал (42) эсхүл зөвшөөрөх байдал (29),
- Сурагчийн хувь хүний онцлог (40),
- Тухайн мэргэжлийн цалин (32),
- Гэр бүлийнхний мэргэжлийн талаарх ойлголт (33),
- Гэр бүлийнхний жендэрийн хэвшмэл ойлголт (31),
- Тухайн мэргэжлээр дадлагажсан байдал (28) зэрэг

нь хамгийн олон давтамжтай дурьдагджээ.

Зураг 5. Сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөгч хүчин зүйлс



Багшийн мэдлэг, чадвар, хандлага сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нь

Багш хичээлийн агуулгыг хэрхэн зааж байгаа байдал, мэргэжлийн талаарх ойлголт, сурагчидтайгаа хэрхэн харилцаж буй хандлагаас хамаарч хүүхдийн мэргэжил сонголтод голлох нөлөөтэй байна. Тухайлбал багш өөрийн хичээлийг сайн зааж, хүүхдийг тухайн сэдвийг сонирхох сонирхолыг өдөөх тусам хүүхдүүд тухайн хичээлтэй холбогдолтой мэргэжлийг сонгох сэдэл нэмэгддэг нь ажиглагдлаа. Энэ тухай судалгаанд оролцогч сурагч хэлэхдээ (О-12):

“Манай биологийн багш хичээлээ маш сайхан заадаг байсан. Багшийгаа харах төдийд л хүүхдүүд биологидоо дуртай болдог. Би биологич, биотехнологич тал руу явъя ч гэж бодож байсан. Даан ч багш солигдоод хичээлээ ойлгохоо больчихсон.”

хэмээсэн нь багшийн заах арга барил хүүхдийн мэргэжил сонголтод нөлөөлдөг болохыг илтгэж байна.

Багш, сурагчдын жендэрийн хэвшмэл ойлголт мэргэжил сонголтод нөлөөлөх нь

Багш нар хүүхдийн мэргэжил сонголтод хэрхэн жендэрээр ялгаатай ханддаг талаар орон нутгийн дунд сургуулийн ахлах анги даасан 14 жилийн туршлагатай эмэгтэй багшийн хэлснээс харж болохоор байна (Багш-1):

“Тооцоолон бодох чадвар сайтай, гүйлгээ ухаантай ч гэдэг юм уу эрэгтэй хүний нэг тийм нэг чадварууд байгаад байдаг. Охидуудад арай нэг жоохон дутмаг...Тиймэрхүү юман дээр угаасаа яалт ч үгүй хүйсийн ялгаа харагдаад байдаг юм байна лээ... Охидуудын хувьд бол эмэгтэй хүний байгалийн нэг юм байдаг даа. Зөөлөн ур чадвар илүү ... нарийн мэргэжлийн юмнууд эмэгтэй хүүхдүүд түлхүү харж сонговол тэр нь дээр, амжилт гаргах нь илүү болоод байгаа юм” гэжээ.

Уг багшийн бодлоор хөвгүүд тооцоололд сайн охид зөөлөн ур чадвартай тул хүнтэй харилцах мэргэжилд тохирно хэмээн үзэж байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголт хэмээн үзэж болохоор байна. Угтаа тооцоолол, хүнтэй харилцах харилцаанд жендэрийн ялгаа байх үндэсгүй юм.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа дэвшүүлсэн зорилгоо биелүүлж сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг Улаанбаатар хот, Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг сум болон Баян-Уул сумын сурагчид, боловсролын салбарт ажиллагсад, хүүхдийн асран хамгаалагчдын төлөөллийг хамруулан гүйцэтгэв. Ингэхдээ чанарын судалгааны ганцаарчилсан (19 ярилцлага) болон бүлгийн ярилцлага (18 удаагийн ярилцлага)-ын аргаар судалгаанд оролцогчдын үзэл бодол, байр суурь, туулж яваа амьдралын туршлагыг сонсож тэмдэглэн, дүн шинжилгээ хийв.

Монгол улсын газарзүйн ялгаатай бүс нутаг болох нийслэл Улаанбаатар хотын төвийн, захын дүүрэг, Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг сум, Баян-Уул сумын дунд сургуулийн сурагчдын төлөөлөл, дунд сургууль болон МСҮТ-ийн багш, нийгмийн ажилтан, аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн, эцэг, эхийн төлөөллийг хамруулахдаа сургуулийн болон гэр бүлийн ялгаатай орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт мэргэжил сонголтод хэрхэн нөлөөлж байгааг судлах чанарын судалгааны арга зүйг боловсруулж, судалгааг гүйцэтгэв.

Судалгааны үр дүнд хэд хэдэн ялгаатай үр дүнг илрүүлснийг багцлан шинжиллээ. Үүнд:

- Сургуулийн орчинд багш нар сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх нөлөө давамгай байсан бөгөөд багш нарын заах арга барил, хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт хүүхдүүдийн мэргэжил сонголтод тодорхой нөлөөтэй байна. Хичээлээ сонирхолтой, хүртээмжтэй заадаг, хүүхдэд ээлтэй хандлагатай багшийн хичээлээр суурилж мэргэжлээ сонгоход жендэр харгалзахгүй байна.
- Ахлах ангийн сурагчдад түгээмэл тохиолдож буй бэрхшээлийн тэргүүнд эх, эцэг асран хамгаалагчидтайгаа ойлголцоход үүсдэг саад тээг байсан бөгөөд энэ нь тэдний мэргэжил сонгоход болон бусад асуудлууд тулгарч буй ахлах ангид суралцаж байх үед ярилцах боломжийг хязгаарлаж, тэдний харилцаанд зааг нэмэгдэж байгаа тал ажиглагдлаа.
- Гэр бүл дэх жендэрийн эрх тэгш бус байдал нь хүчирхийлэл, эр хүйсийн хэт давамгай байдлыг нөхцөлдүүлснээс шалтгаалан охидын бие даасан, хараат бус, дарамт хүчирхийллээс ангид байх сэдэл мэргэжил сонголтод нөлөөлж байна.
- Насны онцлогоос хамааран дунд, ахлах ангийн сурагчид нийгмийн сүлжээн дахь

мэдээллийг ялгаатай шүүлтүүрээр хүлээн авч байна. Энэ нь мэргэжил сонголт, түүний талаарх эргэцүүлэмжид чухал нөлөө үзүүлдэг. Зүй тогтолын хүрээнд харвал дунд ангийн сурагчдад нийгмийн сүлжээн дахь инфлүүнсэрүүдийн нөлөө өндөр байдаг бол ахлах ангийн сурагчдад багасч байх хандлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Abele, A.E. and Wojciszke, B., 2007. Agency and communion from the perspective of self versus others. *Journal of personality and social psychology*, 93(5), p.751.
2. Alonso-Ruido, P., Estívez, I., Varela-Portela, C. and Regueiro, B., 2023. College Students' Stereotyped Beliefs. *Social Sciences*, 12(5), p.302. <https://doi.org/10.3390/socsci12050302>.
3. Clayton, K.L., von Hellens, L.A., and Nielsen, S.H., 2009. May. Gender stereotypes prevail in ICT: A research review. *In Proceedings of the special interest group on management information system's 47th annual conference on Computer personnel research*(pp. 153-158). <https://doi.org/10.1145/1542130.1542160>
4. Eagly, A.H. and Karau, S.J., 2002. Role congruity theory of prejudice toward female leaders. *Psychological review*, 109(3), p.573.
5. Favara, M., 2012. The cost of acting 'girly': Gender stereotypes and educational choices. <https://doi.org/10.2139/ssrn.2189775>.
6. Global gender gap report 2023 World Economic Forum. Available at: <https://www.weforum.org/publications/global-gender-gap-report-2023/> (Accessed: 28 August 2023).
7. Golombok, S. and Fivush, R., 1994. *Gender development*. Cambridge University Press.
8. Gupta, V.K., Turban, D.B. and Bhawe, N.M., 2008. The effect of gender stereotype activation on entrepreneurial intentions. *Journal of applied psychology*, 93(5), p.1053.
9. <https://doi.org/10.1037/0021-9010.93.5.1053>.

10. *Integration of gender responsive financing practices in Mongolia's financial sector (2021) UNDP*. Available at:
11. <https://www.undp.org/mongolia/publications/integration-gender-responsive-financing-practices-mongolias-financial-sector-2021> (Accessed: 27 August 2023).
12. *LGBT Centre (Mongolia)*. 2019. *Submission to the Human Rights Council at the 36th Session of the Universal Periodic Review: Mongolia*. Ulaanbaatar, Mongolia.
- King, T.L., Scovelle, A.J., Meehl, A., Milner, A.J. and Priest, N., 2021. *Gender stereotypes and biases in early childhood: A systematic review*. *Australasian Journal of Early Childhood*, 46(2), pp.112-125. <https://doi.org/10.1177/1836939121999849>.
13. Kuhn, A. and Wolter, S.C., 2022. *Things versus people: Gender differences in vocational interests and in occupational preferences*. *Journal of economic behavior & organization*, 203, pp.210-234.
14. Moya Morales, M.C. and Moya Garyfano, A., 2021. *Evolution of gender stereotypes in Spain: From 1985 to 2018*. *Psicothema*. <https://doi.org/10.7334/psicothema2020.328>.
15. UN. 2023. *Gender stereotyping: OHCHR and women's human rights and gender equality*. Available at <https://www.ohchr.org/en/women/gender-stereotyping#:~:text=A%20gender%20stereotype%20is%20a,personal%20abilities%2C%20pursue%20their%20professional> (Accessed 21 August 2023)
- UNESCO, 2015. *Intangible Cultural Heritage and Gender*.
16. UNESCO. n.d. *Intangible Heritage Home*. Available at: <https://ich.unesco.org/doc/src/34300-EN.pdf> (Accessed: 26 August 2023).
17. UNDP, 2021. *Integration of Gender Responsive Financing Practices in Mongolia's Financial Sector*.
18. Weerathna, R.S. and Napurugala, S., 2019. *The effect of gender on career progression: A conceptual model*. *International Journal of Business and Management*, 14(7), pp.23-27
19. IDLO.n.d. *Бидний сэтгэлгээг хайрцагладаг жендэрийн хэвшмэл ойлголт*, *familycenter.mn*. [Цахим] <https://www.familycenter.mn/news/192> (Хандсан: Хандсан: 24.08.2023).
20. Доржжанцан, Г. Энхмаа, Э. ба Өүлэн, Б. 2023. *Монголын сургуульд транс сурагч байх нь: Кейс цуглуулгын аргаар хийсэн чанарын судалгаа*. Улаанбаатар.
21. *Жендэрийн Үндэсний Хороо*. 2020. *Монгол улс: жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин*. Жендэрийн Үндэсний Хороо, [Цахим] <https://ncge.gov.mn/uploads/research/Gender%20%20new%20mon.pdf> (Хандсан: Хандсан: 25.08.2023).
22. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 2011. *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. [Цахим] <https://legalinfo.mn/mn/detail/253> (Хандсан: 25.08.2023).
23. Насан Туршийн Боловсролын Үндэсний Төв, БСЦУЯ. 2022. *Жендэрийн талаарх үндсэн ойлголт*. UNFPA Mongolia. [Цахим] <https://mongolia.unfpa.org/mn/publications/> (Хандсан: 23.08.2023).
24. НҮБХХ, 2021а. *Монгол улсын санхүүгийн салбарт жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлэх нь*.
25. НҮБХХ, 2021б. *Монгол улсад КОВИД-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа*.
25. Оюунлхам, Г., Ганзориг, Д., Номинбилэг, П., Бэртгөлжин, Э., ба Гэрэлээ, О. 2021. *Жендэрийн тухай таны мэдэх ёстой бүхнийг А-Я үсгэнд, Unread Today*. [Цахим] <https://unread.today/c/gender-everything-guide> (Хандсан: 25.08.2023).